



A member of

## НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

Юу Би Тавэр Плас барилга, 609 тоот  
Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо  
Улаанбаатар хот, Монгол улс  
Утас: +976 7740 4848  
Веб хаяг: [www.nexia.com](http://www.nexia.com)

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

МОНГОЛ БАЗАЛЬТ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

### Аудиторын дүгнэлт

Бид МОНГОЛ БАЗАЛЬТ ХК (цаашид "Компани" гэх)–ийн 2023 оны 12 дугаар сарын 31–ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")–уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"-ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

### Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС–ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Компанийн удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

### Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"–ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДУГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг (үргэлжлэл)

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлagnалуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохиорох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлagnалыг ирүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлagnалыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохиорохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)–ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

### Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориulan гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно



Э.БУЛГАН  
Партнер

УНАРАНДЭЛГЭР  
Аудитор

Улаанбаатар хот, Монгол улс  
Огноо: 2024 оны 3 дугаар сарын 29

МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

**2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН  
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

(Мянган төгрөгөөр)	Тод	2023	2022
Борлуулалтын орлого	6	10,019,108	14,212,925
Борлуулалтын өртөг	7	(6,736,199)	(10,268,992)
Нийт ашиг		3,282,909	3,943,933
Бусад орлого	8	57,977	3,763
Бусад олз / (гарз)	9	(35,091)	118,090
Борлуулалт, маркетингийн зардал	11	(905,602)	(874,050)
Ерөнхий ба удирдлагын зардал	12	(444,069)	(772,902)
Бусад зардал	10	(130,082)	(17,604)
Үйл ажиллагааны ашиг		1,826,042	2,401,230
Хүүний орлого	13	78,985	9,465
Санхүүгийн зардал	13	(539,862)	(213,115)
Татварын өмнөх ашиг		1,365,165	2,197,580
Орлогын татварын зардал	23	(157,571)	(213,066)
ЦЭВЭР АШИГ		1,207,594	1,984,514
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19	1,692,335	-
Бусад дэлгэрэнгүй орлого		1,692,335	-
<b>НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО</b>		<b>2,899,929</b>	<b>1,984,514</b>
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (төгрөгөөр)		21.40	35.18

Хаэсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салишгүй хэсэг болно.

# МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

**2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ  
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

(Мянган төгрөгөөр)	Тод	2023-12-31	2022-12-31
<b>ХӨРӨНГӨ</b>			
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	14	5,729,845	1,428,327
Дансны авлага	15	11,528	323,207
Бусад авлага	16	553,104	546,252
Бараа материал	17	3,087,190	3,940,040
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	18	2,987,446	1,328,046
Нийт эргэлтийн хөрөнгө		<u>12,369,113</u>	<u>7,565,872</u>
Үндсэн хөрөнгө	19	20,045,056	16,848,678
Биет бус хөрөнгө	20	11,911,039	10,721,366
Нийт эргэлтийн бус хөрөнгө		<u>31,956,095</u>	<u>27,570,044</u>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<u>44,325,208</u>	<u>35,135,916</u>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
Дансны өр төлбөр	21	245,144	342,516
Бусад өр төлбөр	22	732,924	4,147
Орлогын татварын өр төлбөр	23	101,514	113,842
Бусад татварын өр төлбөр	24	1,207,573	773,968
Богино хугацаат зээл	25	2,735,501	1,957,000
Урьдчилж олсон орлого	26	488,447	1,171,490
Нөөц өр төлбөр	27	742,278	741,788
Цалингын өр төлбөр	28	575	-
Нийт богино хугацаат өр төлбөр		<u>6,253,956</u>	<u>5,104,751</u>
Урт хугацаат зээл	26	6,268,499	-
Нийт урт хугацаат өр төлбөр		<u>6,268,499</u>	<u>-</u>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<u>12,522,455</u>	<u>5,104,751</u>
<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>			
Хувьцаат капитал	29	5,641,700	5,641,700
Нэмж төлөгдсөн капитал	29	20,509,765	20,509,765
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		<u>3,121,609</u>	<u>1,429,274</u>
Хуримтлагдсан ашиг	29	2,529,680	2,450,426
<b>НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ</b>		<u>31,802,754</u>	<u>30,031,165</u>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		<u>44,325,208</u>	<u>35,135,916</u>

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

# МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

**2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН  
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

(Мянган төгрөгөөр)	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт
	(Тод 29)	(Тод 29)	(Тод 19)	(Тод 29)	
2022 оны 1 сарын 1-ээрх үлдэгдэл	5,641,700	20,509,765	1,429,274	2,095,445	29,676,184
Цэвэр ашиг	-	-	-	1,984,514	1,984,514
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	(665,366)	(665,366)
Зарласан ногдол ашиг	-	-	-	(964,167)	(964,167)
<b>2022 оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>5,641,700</b>	<b>20,509,765</b>	<b>1,429,274</b>	<b>2,450,426</b>	<b>30,031,165</b>
Цэвэр ашиг	-	-	-	1,207,594	1,207,594
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	1,692,335	-	1,692,335
Зарласан ногдол ашиг	-	-	-	(1,128,340)	(1,128,340)
<b>2023 оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>5,641,700</b>	<b>20,509,765</b>	<b>3,121,609</b>	<b>2,529,680</b>	<b>31,802,754</b>

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

**2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН  
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

(Мянган төгрөгөөр)	Тод	2023	2022
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого		10,239,727	16,502,504
Мөнгөн орлогын дүн		10,239,727	16,502,504
Ажиллагсадад төлсөн	(1,418,697)	(1,175,548)	
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(424,238)	(335,458)	
Бараа материал худалдан авахад төлсөн	(9,231,341)	(11,486,924)	
Ашиглалтын зардалд төлсөн	(22,898)	(65,439)	
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд	(4,376)	-	
Хүүний төлбөрт төлсөн	(350,586)	(169,029)	
Татварын байгууллагад төлсөн	(651,835)	(1,877,820)	
Даатгалын төлбөрт төлсөн	(20,588)	(20,179)	
Бусад мөнгөн зарлага	(232,948)	(423,052)	
Мөнгөн зардлын дүн	(12,357,507)	(15,632,873)	
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(2,117,780)	869,631	
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
Хүлээн авсан хүүний орлого	78,985	9,465	
Мөнгөн орлогын дүн	78,985	9,465	
Үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн	(215,744)	(540,577)	
Биет бус хөрөнгө худалдан авахад төлсөн	-	-	
Мөнгөн зарлагын дүн	(215,744)	(540,577)	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(136,759)	(531,112)	
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	9,786,847	18,178,569	
Төрөл бүрийн хандив урамшуулал	-	-	
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	(3,526)	-	
Мөн орлогын дүн	9,783,321	18,178,569	
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	(2,892,000)	(22,119,542)	
Санхүүгийн түрээсийн өр төлбөрт төлсөн	(1,500)	-	
Төлсөн ногдол ашиг	(320,916)	(1,021,212)	
Мөнгөн зарлагын дүн	(3,214,416)	(23,140,754)	
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	6,568,905	(4,962,185)	
Валютын ханшийн зөрүү	(12,848)	90,636	
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	4,301,518	(4,533,030)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14	1,428,327	5,961,357
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14	5,729,845	1,428,327

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

# МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 1 Ерөнхий мэдээлэл

Монгол Базалт ХК ("Компани" гэх) нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу 2007 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр байгуулагдсан, 2018 оны 2 дугаар сарын 19-ний өдөр нэмж хувьцаа гарган нээлттэй хувьцаат компани болсон.

Компанийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Фламинго Тауэрын 7 давхар.

Компанийн улсын бүртгэлийн дугаар: 9010001085

Регистрийн дугаар: 5112494

Компани нь Барилга, хот байгуулалтын яамны 2016 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр, "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" болон "Барилгын тухай" хуулийн дагуу 5 жилийн хугацаатайгаар "Барилгын материалын үйлдвэрлэл: 3.4.1-Эрдэс /чuluun/ хөвөн материалын үйлдвэрлэл" тусгай зөвшөөрлийг авсан.

Компани нь Улсын бүртгэлийн гэрчилгээнд "Гадаад худалдаа" болон "Барилгын материал үйлдвэрлэл" эрхлэхээр бүртгүүлсэн бөгөөд шинэчлэгдсэн Компанийн дүрмэнд дараах үйл ажиллагааг эрхлэхээр заасан байна. Үүнд:

- Барилгын материал үйлдвэрлэл
- Гадаад, дотоод худалдаа
- Төсөл хөтөлбөр
- Сургалт судалгаа

Компанийн дүрмийн сан нь нэг бүр нь 100 төгрөгийн үнэтэй 56,417,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна. Хувьцааны тоо ширхэг болон хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байна.

№	Регистрийн дугаар	Хувьцаа эзэмшигчид	Эзэмшлийн хувь хэмжээ	Хувьцааны тоо ширхэг
1	ЧР65010678	Л.Ариунболд	35.7%	20,140,869
2	ЧР64112065	П.Сайнбилэг	13.3%	7,503,461
3	ЦД88081664	А.Энхгэрэл	7.0%	3,949,190
4	УП90062043	А.Энхмаа	7.0%	3,949,190
5	УП98052329	А.Энхжин	7.0%	3,949,190
6		Бусад*	30.0%	16,925,100
		НИЙТ	100%	56,417,000

\* Бусад хувьцаа эзэмшигчид нь Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалагддаг Компанийн нийт хувьцааны 30% буюу 16,925,100 ширхэг хувьцааны эздийг илэрхийлнэ.

Төлөөлөн удирдах зөвлөл:

№	Регистрийн дугаар	Нэр	Тушаал	Иргэншил
1	ЧР65010678	Л.Ариунболд	Дарга	Монгол
2	ЦД88081664	А.Энхгэрэл	Гүйцэтгэх захирал, Гишүүн	Монгол
3	ХБ47111671	Б.Шаравсамбуу	Аудитын хорооны дарга, Гишүүн	Монгол
4	ЧР64112065	П.Сайнбилэг	Гишүүн	Монгол
5	ЕП58042111	Г.Ганзориг	Гишүүн	Монгол
6	KOR6101194M	Гю Бунг Хан	Гишүүн	БНСУ
7	УК68040211	Ч.Зоригтбаатар	Хараат бус гишүүн	Монгол
8	ИФ69031515	Ш.Энхтөр	Хараат бус гишүүн	Монгол
9	ШД80120714	П.Нямдорж	Хараат бус гишүүн	Монгол

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон аудитлагдсан санхүүгийн тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн шийдвэрээр батлан, гаргахыг зөвшөөрсэн.

#### 2 Компанийн үйл ажиллагааны орчин

Монгол улсын эдийн засаг нь хөгжиж буй зах зээлийн олон шинж чанарыг агуулдаг ба зэс болон нүүрс гэх мэт уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзэл маш мэдрэмтгий юм. Хууль эрх зүйн дүрэм ба татварын зохицуулалтын орчин нь үргэлжлэн хөгжиж, тогтмол өөрчлөгднөн хувьсаж байгаа ба үүнийг олон янзаар тайлбарлаж байна. Монгол Улсын эдийн засгийн ирээдүйн гүйцэтгэл нь БНХАУ-ын эрэлт тасралтгүй, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн тогтвортгүй байдал зэрэгтэй холбоотой бөгөөд Засгийн газраас авч хэрэгжүүлж буй эдийн засаг, санхүү, мөнгөний арга хэмжээний үр нөлөө, татвар, хууль эрх зүйн зохицуулалт, улс төрийн үйл явцаас хамаарна.

#### Орос-Украйны дайны санхүүгийн нөлөө

2022 оны 2 дугаар сарын 24-ний өдөр ОХУ Украян улсын газар нутагт халдсанаар Зүүн Европын геополитикийн нөхцөл хурцад мал байдалд шилжсэн. Хоёр орны хоорондын тэмцэл нь цэрэг армийн үйл ажиллагаанаас гадна улс төр, эдийн засгийн хорио цээрийн аргутудыг хамарч байна. Мөн амь эрсэдсэн хүний тоо хугацаа өнгөрөх тусам нэмэгдсээр байгаагийн зэрэгцээ ОХУ, Украян мөн тэдгээрийн хил залгаа (Беларус гэх мэт) орнуудад үйл ажиллагаа эрхэлдэг, харилцагч талуудтай бизнесийн байгууллагуудад дайны серег үр нөлөө их байна. Дайнаас үүдсэн өндөр инфляцын түвшин, бараа таваарын нийлүүлэлтийн хязгаарлалтууд нь дэлхийн эдийн засаг болон санхүүгийн зах зээлүүдийн өдөр тутмын үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна. Иймд, хоёр орны дайны эргэн тойронд үүсэж буй нэмэлт санхүү, эдийн засгийн өөрчлөлтүүд, тодорхой бус байдлын бодит нөлөө нь Компанийн таамаглааас зөрүүтэй байж болно.

#### Израйль-Газын зурвасын мөргөлдөөний санхүүгийн нөлөө

Израйль-Газын зурвасын мөргөлдөөний дэлхийн санхүү, эдийн засагт үзүүлэх нөлөөг бодитоор үнэлэн, тодорхойлоход хүндрэлтэй байна. Уг мөргөлдөөнөөс үүсэж болох газрын тосны нийлүүлэлтийн хомсдол нь дэлхийн нийтээр эрчим хүчний салбарт шуудаар нөлөөлөх ба газрын тос импортлогч орнуудын хувьд инфляцын түвшин өсөх нөхцөлийг үсгэж болно. Удирдлага нь Израйль-Газын зурвасын одоогоорх нөлөөг Компанийн хувьд материаллаг бус хэмээн үзэж байна. Тухайн мөргөлдөөн удаан хугацаанд үргэлжлэх тохиолдолд улмаар газрын тосны нийлүүлэлтийн хомсдол нь инфляцын өсөлт, үнийн тогтвортгүй байдал зэрэг эдийн засгийн серег үр дагавартай болно.

Удирдлага нь Компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, ажилчдаа дэмжих чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч байна. Гэсэн хэдий ч өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлын ирээдүйн үр нөлөөг урьдчилан таамаглахад хэцүү бөгөөд удирдлагын одоогийн хүлээлт, тооцоолол нь бодит үр дүнгээс ялгаатай байж болно.

#### 3 Нягтлан бodoх бүртгэлийн бодлогууд

##### 3.1 Нийцлийн мэдэгдэл

Компанийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НББОУСЗ")-өөс гаргасан Санхүүгийн Тайлрагналын Олон Улсын Стандартууд ("СТОУС")-ын дагуу бэлтгэгдсэн. Санхүүгийн тайланд холбогдох тэмдэглэлд өөрөөр зааснаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг түүхэн өртгийн үндсэн дээр бэлтгэсэн болно.

Энэхүү тайланг бэлтгэж, тайлгагнаадаа Компанийн бүртгэлийн валют буюу Компанийн үйл ажиллагаа эрхэлж буй эдийн засгийн орчны үндсэн валют болох Монгол Улсын мөнгөн тэмдэгт Төгрөгөөр илэрхийлсэн. Тусгайлсан хэсэгт онцлон зааснаас бусдаар бүх дунг мянгачилж (мянган төгрөгөөр эвсэл төг.мян) толилуулсан.

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 3.2 Тасралтгүй байх зарчим

Удирдлагын зохижмжтой гэж үзсэний дагуу тасралтгүй байх зарчмын дагуу санхүүгийн тайланг бэлтгэсэн.

Компанийн эргэлтийн хөрөнгө 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар 6,115,157 мянган төгрөгөөр богино хугацаат өр төлбөрөөсөө давсан ба тайлант жилийн цэвэр ашиг 1,207,594 мянган төгрөг байсан.

#### 3.3 Таамаглал, тооцоолол ба үнэлгээ хэрэглэх нь

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлгээ хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлгээ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, мөн хөрөнгө, өр төлбөр, орлого зардлын зүйлсийн дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Компани санхүүгийн тайланг бэлтгэхдээ тухайн үеийн боломжит таамаглал, тооцоолол дээр сууринсан. Одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн таамаглал нь зах зээлийн өөрчлөлт эсвэл компанийн хяналтаас гадуурх үйл ажиллагаанаас хамаарч өөрчлөгдөж болзошгүй. Үүнтэй холбоотойгоор аливаа өөрчлөлтүүд тохиолдсон даруйдаа таамаглалын суурь болон тооцоололд тусгагдаг.

Дараа жилийн санхүүгийн тайланд материаллаг залруулга хийх эрсдэл учруулахуйц таамаглал болон тооцооллын тодорхой бус асуудлын талаарх мэдээллийг доор дурдсан тодруулгын хэсэгт багтаасан.

##### 3.3.1 Хойшлогдсон албан татвар

Компани нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг тооцоолоходо Монгол Улсын хуулиар тогтоосон татварын хувь хэмжээ, татвараас хасагдахгүй зардлууд, татварын хуульд орсон өөрчлөлтүүд болон удирдлагын хүлээж буй ирээдүйн үр дүн зэргийг харгалзаж үздэг. Хойшлогдсон орлогын албан татварыг түр зөрүүн дээр суурilan тооцоолдог ба энэ нь санхүүгийн тайланд тайлагнасан орлого, зардал болон татварын хуулийн дагуу тодорхойлсон татвар ногдох орлого, зардлын хоорондох зөрүү юм. Эдгээр түр зөрүүнээс үүссэн татварын нөлөөллийг санхүүгийн тайланд хойшлогдсон татварын хөрөнгө эсвэл өр төлбөрөөр тусгадаг.

Компанийн удирдлага нь хойшлогдсон татварын хөрөнгө хэрэгжихгүй гэж үзэж байгаа тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрдөггүй. Бодит үр дүн нь энэ таамаглалаас зөрүүтэй байх тохиолдолд ирээдүйн тайлант үеүдэд уг таамаглалын залруулга хийх ба тайлант жилийн санхүүгийн байдал болон орлогод материаллаг нөлөө үзүүлэхүйц өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч хойшлогдсон татварын хөрөнгөөр бүртгэх шаардлага тулгарч болно.

##### 3.3.2 Үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа

Компанийн удирдлага нь үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон холбогдох элэгдлийн зардлыг тооцоолдог. Энэхүү тооцооллыг ижил шинж чанар, үүрэгтэй хөрөнгийн бодит ашиглалтын хугацаанд суурilan хийдэг. Энэ нь техник технологийн томоохон шинэчлэл, өрсөлдөгчдийн салбарын хөдөлгөөнд үзүүлж буй хариу үйлдлийн үр дунд их хэмжээгээр өөрчлөгдөж болно. Удирдлага өнөөгийн тооцоолсон ашиглалтын хугацаа нь өмнө нь тооцоолсон ашиглалтын хугацаанаас бага гэж үзвэл элэгдлийн зардлыг нэмэгдүүлж, эсвэл техник болон стратегийн хувьд хоцрогдсон, хаягдсан эсвэл борлуулсан хөрөнгийг данснаас хасаж эсвэл үнэ цэнийг бууруулдаг. Компанийн хөрөнгийн ашиглах хугацааг хэрхэн тодорхойлсныг Тодруулга 5.8-с харна уу.

##### 3.3.3 Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийг тооцоолох

Цэвэр боломжит үнэ цэнэ гэж бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад бараа материалыг худалдан борлуулахаар тооцоолж буй үнээс түүнийг борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүн юм. Гэмтэлтэй, хоцрогдсон болон удаан хугацаанд хөдөлгөөнд ороогүй бараа материал байгаа эсэхийг удирдлагын зүгээс тогтмол хянадаг.

Компани өөрийн тооцооллыг үнэн зөв, бодитой гэж үзэж байгаа боловч аливаа бодит нөхцөл байдал эсвэл нөлөө бүхий хүчин зүйлсээс шалтгаалан тооцоололд өөрчлөлт орсон тохиолдолд ашиг, алдагдал болон өмчид материаллагаар нөлөө үүсж болзошгүй.

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 3.3.4 Бодит үнэ цэнийн хэмжилт

Компани нь хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлоходоо тухайн зах зээл дээрх хамгийн сайн ашиглагдахуйц мэдээллийг ашиглахыг зорьдог. Бодит үнэ цэнийг үнэлгээний арга барилд ашиглагдах өгөгдлүүдэд үндэслэн бодит үнэ цэнийн шатлалаар дараах түвшинд ангилдаг:

- Түвшин 1: Ижил төстэй хөрөнгө, өр төлбөрийн идэвхтэй зах зээлийн жишиг үнэ (тохируулагдаагүй).
- Түвшин 2: Түвшин 1 дэх идэвхтэй зах зээл дээрх хөрөнгө, өр төлбөрийн жишиг үнээс бусад шууд (жишээлбэл: үнэ) болон шууд бусаар (жишээлбэл: үнээс хамааралтай) ашиглаж болох өгөгдлүүд.
- Түвшин 3: Ашиглаж болох зах зээлийн өгөгдөл үндэслээгүй хөрөнгө, өр төлбөрийн өгөгдөл (ажиглаж болохооргүй өгөгдлүүд)

Хэрэв бодит үнэ цэнийн шатлалын түвшин хооронд шилжсэн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжихэд олон төрлийн өгөгдөл ашигласан бол Компани хөрөнгө, өр төлбөрийг бүх хэмжсэн үнэ цэнэд нөлөөлөхүйц бодит үнэ цэнийн шатлалын дундах өгөгдлийн хамгийн бага түвшинд ангилах ба түвшин хоорондын шилжилтийг тухайн шилжилт хийгдсэн тайлант үеийн эцэст хүлээн зөвшөөрнө.

#### 4 Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын өөрчлөлтүүд

##### 4.1. Шинэ буюу шинэчилсэн стандарт болон тайлбар тодруулгуудын хэрэгжилт

Дараах нэмэлт, өөрчлөлт оруулсан стандартууд 2023 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон ба Компани nyaгтлан бodoх бүртгэлдээ мөрдөж эхэлсэн болно:

- СТОУС 17 Даатгалын гэрээ
- НББОУС 8 нэмэлт өөрчлөлт Нягтлан бodoх бүртгэлийн тооцооллын тодорхойлолт
- НББОУС 1 болон СТОУС тайлагналын 2 нэмэлт өөрчлөлт Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын толилуулга
- НББОУС 12 нэмэлт өөрчлөлт Нэг ажил гүйлгээнээс үүсэж буй хөрөнгө ба өр төлбөрийн хойшлогдсон татвар

###### 4.1.1. СТОУС 17 – Даатгалын гэрээ

2017 оны 5 сард НББОУС 3 нь даатгалын гэрээний хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, тайлагнал болон толилуулгын зарчмуудыг тусгасан nyaгтлан бodoх бүртгэлийн иж бүрэн стандарт болох СТОУС 17 Даатгалын гэрээ стандартыг баталсан. СТОУС 17 хүчин төгөлдөр болох хугацаанаасаа эхлэн 2005 онд батлагдсан СТОУС 4 Даатгалын гэрээ стандартыг орлоно. СТОУС 17 нь даатгалыг гаргаж буй аж ахуйн нэгжийн төрлөөс үл хамааран бүх төрлийн (жишээлбэл амьдралын, ердийн, шууд даатгал болон давхар даатгал гэх мэт) мөн түүнчлэн тодорхой онцлог бүхий баталгаа болон санхүүгийн хэрэгслийг хамаарна.

Хамрах хүрээний хувьд цөөн хэдэн зүйлсийг үл хамаарна. СТОУС 17-ийн ерөнхий зорилго нь даатгалын гэрээний nyaгтлан бodoх бүртгэлийн загварыг даатгагчид илүү ашигтай, тогтвортой байлгаж өгөх явдал юм. СТОУС 4-т тавигдах шаардлагаас ялгаатай нь СТОУС 17 нь nyaгтлан бodoх бүртгэлийн холбогдох бүх талыг хамарсан даатгалын гэрээний цогц загварыг гаргаж өгсөн. СТОУС 17-ийн гол цом нь ерөнхий загвар бөгөөд нэмэлтээр:

- Сонголттой оролцох шинж чанар бүхий гэрээнд тохирсон тодорхой тохируулга (хувьсах төлбөрийн хандлага)
- Богино хугацаат гэрээнд голчлон зориулсан хялбаршуулсан арга (шимтгэл хуваарилах арга)

СТОУС 17 нь 2023 оны 1 сарын 1 болон түүнээс хойш тайлангийн хугацаанд хүчин төгөлдөр болох ба харьцуулах мэдээллийн хамт толилуулах шаардлагатай. Компанийн үзсэнээр энэхүү шинэ стандарт нь материаллаг нөлөө өдгөө санхүүгийн тайланд үзүүлээгүй болно.

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 4.1.2. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт – НББОУС 8 нэмэлт өөрчлөлт

2021 оны 2-р сард Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл ("НББОУС 3") нь НББОУС 8-ийн НББ-ийн тооцооллын тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэхүү өөрчлөлтүүд нь НББ-ын тооцооллын өөрчлөлт, НББ-ийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга зэргийн хоорондын ялгааг тодорхойлсон. Мөн аж ахуй нэгжүүд НББ-ийн тооцооллыг боловсруулахад хэмжилтийн техник болон өгөгдөл хэрхэн хэрэглэдгийг тодруулж өгсөн.

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс эсвэл түүнээс хойших тайлант жилээс хүчин төгөлдөр болох бөгөөд НББ-ийн тооцооллын өөрчлөлт, НББ-ийн бодлогын өөрчлөлтүүдэд үйлчилнэ. Баримтуудыг толилуулсан тохиолдолд эрт хэрэгжүүлэхийг зөвшөөрнө. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь Компанийн санхүүгийн тайландаа материаллаг нөлөө үзүүлээгүй болно.

#### 4.1.3. НББ-ын бодлогын толилуулга – НББОУС 1 болон СТОУС Практик тайлагналын 2 нэмэлт өөрчлөлтүүд

2021 оны 2-р сард НББОУС 3-аас НББОУС 1 болон СТОУС Практик тайлагналын 2-т материаллаг байдлын дүгнэлт хийх нэмэлт өөрчлөлтүүд оруулсан. Энэ нь НББ-ийн толилуулгадаа материаллаг байдлын дүгнэлтийг заавар жишээг багтаасан.

Нэмэлт өөрчлөлтүүд нь аж ахуйн нэгжүүдэд "гол" нягтлан бодох бүртгэлийн толилуулах шаардлагыг "материаллаг" нягтлан бодох бүртгэлийн бодлогоо ил тод болгох шаардлагаар сольж, аж ахуйн нэгжүүд материаллаг байдлын үзэл баримтлалыг хэрхэн ашиглах талаар зааварчилгааг нэмж оруулснаар илүү хүртээмжтэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгыг гаргахад туслах зорилготой юм.

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс эсвэл түүнээс хойших тайлант жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд өмнө хэрэгжүүлэхийг зөвшөөрнө. Практик тайлагналын 2 нь НББ-ийн мэдээлэлд материаллаг байдлыг тодорхойлох заавал шаардагдахгүй зааварчилгааг гаргасан тул энэ өөрчлөлтөд хүчин төгөлдөр болох огноо шаардлагагүй болно.

Компани энэхүү нэмэлт, өөрчлөлт нь НББ-ийн бодлогын тодруулгадаа материаллаг нөлөөгүй байсан гэж үзсэн.

#### 4.1.4. Нэг ажил гүйлгээнээс үүсэж буй хөрөнгө ба өр төлбөрийн хойшлогдсон татвар –НББОУС 12 нэмэлт өөрчлөлт

НББОУС 3 нь 2021 оны 5 сард НББОУС 12 Орлогын албан татварт нэмэлт өөрчлөлт оруулсан. Уг өөрчлөлтөөр НББОУС 12-ын дагуу хойшлогдсон татварын хөрөнгө өр төлбөрийг анх удаа хүлээн зөвшөөрөхөөс чөлөөлөгдөх цар хүрээг нарийвчлан тусгаснаар татвар ногдох орлогоос хасагдах болон татвар ногдох тэнцүү дүнтэй түр зөрүү үүсгэж байгаа гүйлгээнүүдийг чөлөөлөгдөх цар хүрээнд хамааруулахгүй болсон.

Энэхүү нэмэлт өөрчлөлтийг санхүүгийн тайландаа толилуулж буй зэрэгцүүлсэн тайлант жилийн эхэнд эсхүл тайлант жилийн эхнээс хойших хугацаанд гарсан гүйлгээнд дагаж мөрднө. Мөн, санхүүгийн тайландаа толилуулж буй зэрэгцүүлсэн тайлант тайлант хугацааны эхэнд татвар ногдох болон татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүү үүсгэж буй түрээс болон татан буулгах үүрэгтэй холбоотой бүх гүйлгээнд хойшлогдсон татварын хөрөнгө (татвар ногдох ашиг хангалтай үед), өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

Компани одоогоор энэхүү нэмэлт өөрчлөлт нь НББ-ийн бодлогын тодруулгадаа материаллаг нөлөөгүй гэж үзсэн.

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 4.2. Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартууд

Компанийн санхүүгийн тайлангуудыг баталж гаргах өдрийн байдлаар батлагдаж гарсан ба 2024 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхлэх стандартууд болон тайлбаруудын жагсаалтыг дор үзүүлэв. Компани энэхүү стандартуудыг шаардлагатай тохиолдолд хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс мөрдөх хандлагатай байна.

- |                              |  |
|------------------------------|--|
| • СТОУС 6 – нэмэлт өөрчлөлт  | Борлуулах болон буцаан түрээслэх үеийн түрээсийн өр төлбөр |
| • НББОУС 1 – нэмэлт өөрчлөлт | Өр төлбөрийн богино, урт хугацааны ангилал                 |

#### 5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо

##### 5.1 Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө, урт ба богино хугацаат өр төлбөрийн ангилал

Компани нь санхүүгийн тайландаа хөрөнгийг эргэлтийн ба эргэлтийн бус, өр төлбөрийг урт ба богино хугацаат гэж ангилдаг. Хөрөнгө нь доорх тохиолдолд эргэлтийн байдал:

- Эргэлтэд оруулахаар тооцоолж буй мөн хэвийн үйл ажиллагааны үед борлуулах болон хэрэглэх зорилготой
- Зөвхөн арилжаалах зорилгоор эзэмшиж буй
- Тайлант үеийн дараах 12 сарын дотор эргэлтэд орохоор хүлээгдэж буй эсвэл
- Тайлант үеийн дараах 12 сарын дотор өр төлбөр төлөх болон солилцохыг хязгаарлаагүй бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Бусад бүх хөрөнгө эргэлтийн бус гэж ангилагддаг. Доорх тохиолдолд өр төлбөр нь богино хугацаатай байна:

- Хэвийн үйл ажиллагааны циклд төлөгдөхөөр хүлээгдэж буй
- Зөвхөн арилжаалах зорилгоор эзэмшиж буй
- Тайлант үеийн дараах 12 сарын дотор төлөгдөхөөр хүлээгдэж буй эсвэл
- Тайлант үеийн дараах 12 сарын дотор өр төлбөр барагдуулах хугацааг хойшлуулах нөхцөлт бус эрх байхгүй

Компани нь бусад бүх өр төлбөрийг урт хугацаат гэж ангилдаг.

#### 5.1 Гадаад валютын хөрвүүлэг

Компанийн санхүүгийн тайланг Компани үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр илэрхийлнэ. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгж рүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютын бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар дахин хөрвүүлдэг. Мөнгөн зүйлсийн төлөгдсөн эсвэл хөрвүүлснээс үүссэн бүх зөрүүг ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ.

Түүхэн өртөг нь гадаад валютын хэмжигдэх мөнгөн бус зүйлсүүдийг анхны гүйлгээний өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютын хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнээрээ хэмжигдэх мөнгөн бус зүйлсийг хөрвүүлснээс үүссэн олз, гарзыг тухайн зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг хүлээн зөвшөөрөхтэй адилаар авч үзнэ.

#### 5.2 Харилцагчтай байгуулсан гэрээний орлого

Харилцагчидтай хийсэн гэрээний орлогыг бараа бүтээгдэхүүн борлуулсан эсвэл үйлчилгээг үзүүлсний үр дүнд Компанийн хүлээж авахаар хүлээгдэж буй орлогыг тусгасан дунгээр хүлээн зөвшөөрнө. Орлогыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө дараах тусгай хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг хангах ёстай.

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 5.3 Хүүний орлого

Хүүний орлогыг үр ашигт хүүний аргад үндэслэн хүлээн зөвшөөрнө. Үр ашигт хүүний арга гэдэг нь хорогдуулсан өртгөөр хэмждэг санхүүгийн бүх хэрэглүүр, хүүний орлогыг шаардлагатай үед санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн бүртгэлийн дүнтэй цэвэршүүлсэн богино хугацааны буюу санхүүгийн хэрэглүүрийн таамагласан хугацаанд тооцоолсон, ирээдүйд хүлээж авах буюу төлөх мөнгөн урсгалын бууруулсан хүүний түвшинг ашиглах арга юм.

#### 5.4 Гэрээний өр төлбөр

Гэрээний өр төлбөр гэдэг нь Компани харилцагчтай тохиролцон бараа бүтээгдэхүүн борлуулсан эсвэл үйлчилгээ үзүүлснээр нөхөн төлбөр хүлээн авсан бол (хүлээн авах бол) хүлээх хариуцлага юм. Хэрвээ Компани бараа бүтээгдэхүүн борлуулах эсвэл үйлчилгээ үзүүлэхээс өмнө харилцагч төлбөрийг төлбөл, төлбөр хийгдсэн өдөр эсвэл хийгдэх ёстой өдөр (аль эртээр нь) гэрээний өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Компани гэрээний дагуу үүргээ гүйцэтгэж дуусах үед гэрээний өр төлбөрийг орлого гэж хүлээн зөвшөөрнө.

#### 5.5 Зардал

Зардлууд нь тайлант хугацааны үед өөрийн хөрөнгийг бууруулж (хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгохоос бусад бууралт) буй эдийн засгийн өгөөжийн гадагшлах урсгал, хөрөнгийн бууралт, өр төлбөрийн нэмэгдлээс үүснэ. Зардлуудыг гарсан үед нь ашиг алдагдлын тайланда хүлээн зөвшөөрнө.

#### 5.6 Ажилчдын тэтгэмж

##### 5.6.1 Богино хугацааны тэтгэмж

Цалин хөлс болон түүнтэй холбогдох бусад зардлуудыг Компанийн ажилтнуудаас холбогдо үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

##### 5.6.2 Заавал төлөх даатгалын шимтгэлүүд

Монгол улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь ашиг, алдагдлын тайланда зардлаар хүлээн зөвшөөрнө.

#### 5.7 Татвар

##### 5.7.1 Тайлант хугацааны орлогын албан татвар

Одоогийн болон өмнөх тайлант хугацааны өнөөгийн албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан.

Эдгээр зүйлд холбоотой тайлант жилийн орлогын албан татварыг орлого үр дүнгийн тайланда биш шууд өөрийн хөрөнгөд хүлээн зөвшөөрнө. Удирдлага НББ-ийг хэрхэн хётлөхийг холбогдох татварын хууль, журмуудад тодорхой зааж өгөөгүй, нэмэлт тайлбар тодруулга шаардлагатай тийм шинэ нөхцөл байдал үүссэн эсэхийг тодруулахын тулд тодорхой хугацаа тутамд татварын тайлангаа хянаж үздэг ба шаардлагатай бол сан байгуулдаг.

##### 5.7.2 Хойшлогдсон орлогын татвар

Хойшлогдсон орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн хоёрын хооронд түр зөрүүний дүнгээс тайлан тэнцлийн аргыг хэрэглэн тооцдог.

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Хойшлогдсон албан татварын өр төлбөрийг дор дурдсанаас бусад бүх түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хойшлогдсон албан татварын өр төлбөр нь гүүдвиллийг анх хүлээн зөвшөөрөх үед эсвэл бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээнээс үссэн, уг гүйлгээ нь НББ-ийн ашиг (алдагдал), татвар ногдох ашиг (алдагдал) – ийн аль алинд нөлөө үзүүлэхгүй байгаа үед,
- Түр зөрүү нь охин болон холбоотой компаниудад оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан компани дахь ашиг сонирхол зэрэгтэй холбоотойгоор үссэн, түр зөрүүг хэзээ арилгахыг толгой компани, хөрөнгө оруулагч эсвэл хамтрагч тал хянаж байгаа, түр зөрүү нь ойрын хугацаанд арилахгүй байх магадлалтай байгаа үед

Дор дурдсанаас бусад тохиолдолд хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийг татвар ногдох орлогоос хасгахаа бүх түр зөрүүнүүд, ирээдүйд шилжүүлэн тооцох, ашиглаагүй татварын бүх хөнгөлөлт ба алдаглуудад (эдгээр түр зөрүү, хөнгөлөлт, алдаглуудыг хасаж болох татвар ногдох орлогын ирээдүйд орж ирэх нь тодорхой болсон үед) хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Татвар ногдох орлогоос хасгахаа түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон албан татварын хөрөнгө нь бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг анх хүлээн зөвшөөрөх үед үссэн ба гүйлгээ гарах үед, НББ-ийн болоод татварын ашиг (алдагдал) – ийн аль алинд нөлөө үзүүлэхгүй байгаа үед;
- Татвар ногдох орлогоос хасгахаа түр зөрүү нь охин болон холбоотой компаниудад оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотойгоор үссэн бол хойшлогдсон албан татварын хөрөнгийг, түр зөрүү нь ойрын хугацаанд арилах магадлалтай, түр зөрүүг хасаж болох татвар ногдох орлого орж ирэх нь тодорхой болсон үед зөвхөн хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг тайлант хугацаа бүрийн эцэст хянаж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг хэсэгчлэн эсвэл бүхлээр нь нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхойгүй болсон үед харгалзах хэмжээгээр хөрөнгийн дүнг бууруулна. Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхой болсон үед харгалзах хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн тайлант хугацааны эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээнүүд дээр үндэслэн хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах тайлант хугацаанд хэрэглэгдэхээр хүлээгдэж буй татварын хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцно.

Хэрэв өнөөгийн татварын хөрөнгийг татварын өр төлбөрт суутгуулах хууль ёсны эрхтэй бөгөөд хойшлогдсон татварууд нь нэг татвар төлөгч аж ахуйн нэгж ба нэг татварын байгууллагатай холбоотой байгаа бол хойшлогдсон албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлж болно.

#### 5.7.3 Нэмэгдсэн өртгийн албан татвар

Орлого, зардал болон хөрөнгүүд нь доорооос бусад тохиолдолд Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар (НӨАТ) –гүй цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрөгддөг:

- Хөрөнгө эсвэл үйлчилгээг худалдан авахад төлсөн НӨАТ-ыг татварын байгууллагаас буцаан авах боломжгүй үед уг НӨАТ-ыг хөрөнгө худалдан авалтын өртгийн нэг хэсгээр эсвэл зардлын нэг хэсгээр (аль тохиромжтойгоор) хүлээн зөвшөөрнө.
- НӨАТ-ын дун орсон дүнгээр илэрхийлэгдэх авлага ба өр төлбөр.

Татварын байгууллагаас авах эсвэл татварын байгууллагад өгөх өр төлбөрийн цэвэр дүнг санхүүгийн байдлын тайландаа авлага эсвэл өр төлбөрийн нэг хэсгэг болгон толилуулна.

#### 5.8 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан тохиолдолд л тухайн үндсэн хөрөнгийн сольсон хэсгийн өртгийг тухай бүрт нь энэ өртөгт оруулна. Үндсэн хөрөнгийн томоохон хэсгийг үе шаттайгаар солих шаардлагатай болсон үед

НЕКСИА ГЛОБАЛ  
МОНГОЛИА АУДИТ ХХК

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Компани нь ийм хэсгүүдийг тусдаа ашиглалтын хугацаа, элэгдэлтэй бие даасан хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

Үүнтэй адил, үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан бол үндсэн хяналт хийх үед түүний өргтийг үндсэн хөрөнгийн бүртгэлийн дүнд оруулна. Бусад бүх засвар үйлчилгээний зардлыг гарсан үед нь ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайландаа тусгана. Хүлээн зөвшөөрсний дараах үед компьютер, бусад хөрөнгө, тавилга эд хогшил ба машин тоног төхөөрөмж нь хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өргөөр илэрхийлдэг. Бусад үндсэн хөрөнгийг дараах ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргыг ашиглан хорогдуулна:

Хөрөнгийн төрөл	Ашиглалтын хугацаа (жилээр)
Барилга	25 жил
Тоног төхөөрөмж	10 жил
Автомашин	10 жил
Тавилга	10 жил
Компьютер	2 жил
Бусад хөрөнгө	10 жил

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашгийн хүлээлт үгүй болсон үед үл хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (хэрэв байгаа бол), дансны цэвэр үнэ хоёрын зөрүүг орлогын тайландаа хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр ашгийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг.

#### 5.9 Биет бус хөрөнгө

Ашиглагдах жил нь тодорхой, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өргөөс нь хуримтлагдсан элэгдэл ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжсэн. Биет бус хөрөнгийн хорогдуулгыг шулуун шугамын аргаар, биет бус хөрөнгийн ашиглалтын жилээр тооцоолсон. Тооцоолсон ашиглалтын жил болон элэгдэл бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг. Ашиглагдах жил нь тодорхойгүй, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өргөөс нь үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжсэн.

Биет бус хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл үндсэн хөрөнгийн зүйлийг бүртгэлээс хасдаг. Биет бус хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг алдагдалд тусгана.

Газар эзэмших эрхийг дахин үнэлгээний аргаар бүртгэдэг. Дахин үнэлгээний загварын аргыг хэрэглэж байх үед үнэлгээг тогтмол хийх ба ингэснээр тухайн хөрөнгийн үнэлгээ нь тайлант жилийн эцсээрх бодит үнэ цэнээсээ хэт зөрөхгүй байхыг шаарддаг. Дахин үнэлгээний загварын аргаар бүртгэж буй хөрөнгөтэй нэг ангилалд хамаарах хөрөнгүүдийг мөн адил дахин үнэлгээний аргаар бүртгэх ёстой. Дахин үнэлгээний загварын аргын үед хөрөнгийн хорогдол тооцох арга нь өргтийн аргатай ижил байдаг.

Дахин үнэлгээгээр биет бус хөрөнгө нь үнэ цэнийн өсөлттэй байх тохиолдолд үнэ цэнийн өсөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч, эздийн өмчийн дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц дансанд бүртгэнэ. Харин хөрөнгө нь бодит үнэ цэнийн бууралттай байх үед дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц дансыг бууруулах, үлдэгдэлгүй тохиолдолд ашиг, алдагдлын тайландаа зардаалаар хүлээн зөвшөөрнө.

Дахин үнэлгээний аргаар бүртгэж байсан хөрөнгийг зарж борлуулах тохиолдолд тухайн хөрөнгөтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн үлдэгдлийг хуримтлагдсан ашиг руу хаах, эсвэл дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц дансанд үлдээж болно. Аль ч тохиолдолд зарж борлуулсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн үлдэгдлийг ашиг, алдагдлын тайландаа хүлээн зөвшөөрхгүй болно.

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 5.10 Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн хэрэглүүр нь нэг байгууллагын санхүүгийн хөрөнгийг өсгөж нөгөө байгууллагын санхүүгийн өр төлбөр эсвэл эздийн өмчийг өсгөдөг аливаа гэрээ юм.

##### 5.10.1 Санхүүгийн хөрөнгө

Анхны хүлээн зөвшөөрөлт болон хэмжилт

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд эсвэл ашиг алдагдлын тайланд бүртгэдэг ба дараа нь хорогдуулсан өртгөөр нь хэмждэг. Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээний шинж тэмдгийг харгалзан үзэж мөн Компанийн уг санхүүгийн хөрөнгийг зохицуулах бизнесийн моделийг харгалзан ангилна. Санхүүгийн томоохон хэсгийг агуулаагүй эсвэл практик хэрэглээ хийгээгүй авлагын дансаас бусад санхүүгийн хөрөнгийг анхлан бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Ашиг алдагдлын тайланд бодит үнэ цэнээр бүртгэгдээгүй санхүүгийн хөрөнгийг гүйлгээний өртгөөр бүртгэнэ. Санхүүгийн томоохон хэсгийг агуулаагүй эсвэл практик хэрэглээ хийгээгүй авлагын дансыг НББОУС 15-ийн дагуу гүйлгээний дүнгээр нь хэмждэг. “Харилцагчтай хийсэн гэрээний орлого” хэсгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг харна уу.

Санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртөгт ангилж хэмжихийн тулд, эсвэл бусад ашиг алдагдлын тайланд бодит үнэ цэнээр бүртгэхийн тулд санхүүгийн хөрөнгө нь мөнгөн гүйлгээний “үндсэн болон хүүгийн төлбөр (ҮБХТ)” хэсгийн үндсэн дүнгийн үлдэгдэлийг ихэсгэх хэрэгтэй. Энэхүү үнэлгээг ҮБХТ тест гэж нэрлэдэг бөгөөд хэрэглүүрийн түвшинд хийдэг. Компанийн санхүүгийн хөрөнгийг зохицуулдаг бизнес модел нь мөнгөн гүйлгээг үүсгэхийн тулд санхүүгийн хөрөнгийг хэрхэн зохицуулдаг талаар дурдсан байдаг. Мөнгөн гүйлгээ нь гэрээт мөнгөн гүйлгээг цуглуулснаас, санхүүгийн хөрөнгийг борлуулснаас, эсвэл аль альнаас нь үүсэх эсэхийг бизнес модел нь тодорхойлдог.

Хуулийн дагуу тодорхой цаг хугацаанд санхүүгийн хөрөнгийг хүргэхийг шаарддаг худалдан авалт эсвэл борлуулалт нь худалдаа хийсэн өдрөөр хүлээн зөвшөөрөгддөг. Жишээлбэл: Компани хөрөнгийг худалдаж авсан эсвэл борлуулсан өдөр.

Дараах үеийн хэмжилт

Дараах үеийн хэмжилтийн зорилгоор санхүүгийн хөрөнгийг дөрөв ангилдаг:

- Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгө (өрийн хэрэглүүр)
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх, хуримтлагдсан ашиг, алдагдлыг орлого, зардлын тайланд бүртгэх санхүүгийн хөрөнгө (өрийн хэрэглүүр)
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх, хуримтлагдсан ашиг, алдагдлыг орлого, зардлын тайланд бүртгэхгүй санхүүгийн хөрөнгө (эздийн өмчийн хэрэглүүр)
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө

Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгө (өрийн хэрэглүүр)

Энэ төрөл нь Компанид хамгийн их тохирдог. Дараах хоёр нөхцөл бүрдсэн тохиолдолд Компани санхүүгийн хөрөнгөө хорогдуулсан өртгөөр хэмжинэ:

- Гэрээт мөнгөн гүйлгээг цуглуулах зорилготой бизнесийн моделийн дагуу эзэмшдэг санхүүгийн хөрөнгө.
- Үндсэн төлбөр болон үлдэгдэл үндсэн дүнгийн хүүний төлбөр болох мөнгөн гүйлгээг тодорхой өдруүдэд бий болгодог санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцлүүд.

Хорогдуулсан өртгөөрхөн санхүүгийн хөрөнгө нь тайлангийн дараа үед үр ашигт хүүгийн аргаар хэмжигдэх ба үнэ цэнийн бууралтад орно. Хөрөнгө нь үл хүлээн зөвшөөрөгдөх, өөрчлөгдэх эсвэл үнэ цэнийн бууралтад орсон тохиолдолд олз гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Хорогдуулсан өртгөөрхөн санхүүгийн хөрөнгө нь худалдааны болон бусад авлага, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө зэргээс бүрдэнэ.

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### Үл хүлээн зөвшөөрөлт

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгийн хэсгийг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн ургал хүлээн авах эрх нь дууссан;
- Компани нь тухайн хөрөнгөөс мөнгөн ургал хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн; мөн: а) компани хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн; эсвэл б) компани тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Компани хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Компанийн уг хөрөнгөнд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Компани холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөрийг Компанийн хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ.

Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Компанийн төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

#### Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Компани нь бодит үнэ цэнийн бууралт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэхгүй бүх өрийн хэрэглүүрийн хувьд "зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал (ЗҮЦХА)" – ыг тооцож сан байгуулна. ЗҮЦХА нь гэрээний дагуу хийгдэх мөнгөн гүйлгээ ба Компанийн хүлээж буй бүх мөнгөн ургалуудыг анхны үр ашигт хүүг ашиглан тооцоолж хассан дунгийн зөрүү дээр суурилдаг. Компаний хүлээгдэж буй мөнгөн ургалууд гэдэг нь гэрээний барьцаа хөрөнгө эсвэл гэрээний нөхцөлтэй салшгүй холбоотой зээлийн бусад сайжруулалтын мөнгөн ургалуудыг хэлнэ.

ЗҮЦХА-г хоёр үе шатаар хүлээнэ зөвшөөрнө. Хэрэв анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гаралгүй бол ЗҮЦХА-г дараагийн 12 сарын болзошгүй алдагдлын магадлалд үндэслэнэ. Анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц ихэссэн тохиолдолд төлбөрийн хугацааг үл харгалзан үлдсэн бүх хугацааны туршид хүлээгдэж буй ЗҮЦХА-г байгуулна.

Компанийн зүгээс гэрээний төлбөр хугацаа 90 хоногоос хэтэрсэн тохиолдолд зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн гэж үздэг.

Компанийн гэрээний төлбөр 365 хоногоос дээш хугацаагаар хэтэрсэн тохиолдолд тухайн санхүүгийн хөрөнгийг алдагдал гэж үзнэ. Гэвч зарим тохиолдолд Компанийн хугацаанаас үл хамааран гэрээний үлдэгдэл төлбөрийг бүрэн хэмжээгээр авах магадлал багатай байна гэж үзвэл тухайн санхүүгийн хөрөнгийг алдагдал гэж тооцож болно. Гэрээнд заасан мөнгөн ургалыг олох хүлээлт байхгүй гэж үзсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг данснаас хасна.

#### 5.10.2 Санхүүгийн өр төлбөр

##### Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Санхүүгийн өр төлбөрийг аль зохистой ангилалд нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх, зээл ба зээллэг, эсвэл үр нөлөөтэй хейджингийн хэрэглүүрээр анх хүлээн зөвшөөрнө. Бүх санхүүгийн өр төлбөрүүдийг анх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба зээл, зээллэг болон өр төлбөрийн хувьд шууд хамааралтай гүйлгээний зардлыг хассаны дараах дунгээр хүлээн зөвшөөрнө. Компанийн санхүүгийн өр төлбөрт бусад өр төлбөр болон холбоотой талын өр төлбөр орно. Бүх санхүүгийн өр төлбөрийг зээл ба зээллэг гэж ангилдаг.

##### Үл хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн өр төлбөрийг төлхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзэх ба бүртгэлийн дунгийн зөрүүг орлого, зардлын дансанд хүлээнээл МОНГОЛИА АУДИТ ХХК зөвшөөрнө.

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 5.11 Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх

Хэрэв байгууллага хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр тайлан тэнцэлд толилуулах эрхтэй.

#### 5.12 Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн хэрэглүүрийн богино хугацааны төлбөртэй холбоотойгоор уг хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь дансны үнэтэй ойролцоо байна гэж удирдлага тооцсон.

#### 5.13 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд бэлэн мөнгө болон банкин дахь дансанд байршуулсан мөнгө орно. Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор, банкин дахь бэлэн мөнгө нь дээр тодорхойлсноор банкин дахь харилцах болон богино хугацаат хадгаламжийн дүнгээс бүрдэнэ.

#### 5.14 Түрээс

Тухайн гэрээ нь түрээсийн гэрээ эсвэл түрээс агуулж байгаа эсэхийг тодорхойлоходоо гэрээний агуулга дээр үндэслэх ба гэрээг гүйцэтгэхэд тусгай хөрөнгийг ашиглах шаардлагатай эсэх ба гэрээ нь хөрөнгийг ашиглах эрхийг шилжүүлж байгаа эсэх зэргийг үнэлж үзэх шаардлагатай.

##### 5.14.1 Компани түрээслэгч байх үед

Компани богино хугацаат түрээс болон бага үнэ цэнэ бүхий хөрөнгийн түрээсээс бусад бүх түрээсийн хүлээн зөвшөөрөлт болон хэмжилтийн нэг аргыг хэрэглэнэ. Компани түрээсийн төлбөрийг төлөөлж “түрээсийн өр төлбөр”-ийг хүлээн зөвшөөрч, тодорхойлсон хөрөнгийг түрээслэн ашиглах эрхийг төлөөлж “ashiглах эрхтэй хөрөнгө”-ийг хүлээн зөвшөөрнө.

##### 5.14.2 Ашиглах эрхтэй хөрөнгө

Компани ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн эхлэх өдөр (хөрөнгийг ашиглаж эхлэх боломжтой болсон өдөр) эхлэн хүлээн зөвшөөрнө. Ашиглах эрхтэй хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, аливаа үнэ цэнийн бууралтын алдагдлыг хасч өртгөөр нь хэмжих бөгөөд түрээсийн өр төлбөрийг дахин үнэлэхэд тохируулна. Ашиглах эрхтэй хөрөнгийн өртөг нь хүлээн зөвшөөрөгдсөн түрээсийн өр төлбөр, анхны шууд өртөг, түрээсийн урамшууллыг хүлээн авахаас өмнө буюу өмнөх өдрөөс эхлэн хийсэн түрээсийн төлбөрүүд багтана.

##### 5.14.3 Түрээсийн өр төлбөр

Компани түрээсийн хугацааны туршид төлөх төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнээр хэмжсэн түрээсийн өр төлбөрийг түрээс эхлэх өдөр хүлээн зөвшөөрнө. Түрээсийн төлбөр гэдэгт аливаа урамшуулал хөнгөлөлтийг хассан түрээсийн тогтмол төлбөрөөс гадна хувь хэмжээнээс хамаарах хувьсах шинжтэй төлбөр, үлдэгдэл үнийн баталгааны дагуу төлөхөөр хүлээгдэж буй төлбөрүүдийг хамруулан авч үзнэ. Хувьсах шинжтэй түрээсийн төлбөр нь ямар нэг индекс, хувь хэмжээнээс хамааралгүй (бараа материал үйлдвэрлэхэд зориулж гаргаагүй бол) бол түүнийг тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрнө.

#### 5.15 Өөрийн хөрөнгө

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөнд ангилна. Энгийн хувьцааны ногдол ашгийг зарласан үедээ өөрийн хөрөнгөнд хүлээн зөвшөөрдөг. Өөрийн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой гүйлгээний зардлыг татвар сутгасан дунгээр нь өөрийн хөрөнгөнөөс хасна. Өөрийн хөрөнгийн гүйлгээний өртөгт зөвхөн өөрийн хөрөнгийн гүйлгээнд шууд холбоотой гаднын нэмэгдүүлсэн өртгөөс бусад өртгийг оруулахгүй.

#### 5.16 Болзошгүй өр төлбөр

Болзошгүй өр төлбөрүүд нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөгддэггүй бөгөөд санхүүгийн тайлангийн тодруулгад толилуулдаг. Харин ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг **компани-хүртэх** магадлалтай болсон үед санхүүгийн тайлангийн тодруулгад толилуулна.

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 5.17 Холбоотой талууд

Холбоотой талууд гэдэгт Компанитай дараах байдлаар холбогдсон аж ахуй нэгж болон хувь хүн орно. Үүнд:

- a) Компанитай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:
  - i) Компанид дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
  - ii) Компанид томоохон нелөөлөлтэй эсвэл
  - iii) Компанийн эсвэл Компанийн толгой компанийн гол удирдах албан тушаалтнуудын нэг.
- b) Дараах нөхцлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуй нэгж нь Компанид хамааралтай болно. Үүнд:
  - i) Аж ахуй нэгж болон Компани нь нэг ижил Компаниын гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой).
  - ii) Нэг аж ахуй нэгж нь нөгөө аж ахуй нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани (эсвэл нөгөө аж ахуй нэгж нь гишүүн болох Компанийн хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани).
  - iii) Аль аль аж ахуй нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд.
  - iv) Нэг аж ахуй нэгж нь гуравдагч аж ахуй нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуй нэгжийн хараат компани.
  - v) Аж ахуй нэгж нь Компанийн эсвэл Компанитай холбоотой аж ахуй нэгжийн ажиллагдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог. Хэрвээ Компани нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Компанитай холбоотой тал болно.
  - vi) Аж ахуй нэгжийг (a)-д тодорхойлсон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог.
  - vii) (a) (i)-д тодорхойлсон хувь хүн нь аж ахуй нэгжид томоохон нелөөлөлтэй эсвэл уг аж ахуй нэгжийн (эсвэл аж ахуй нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.
  - viii) Аж ахуй нэгж нь эсвэл Компанийн аль нэг гишүүн нь Компани эсвэл Компанийн толгой компанийд гол удирдах албан тушаалтай.

**МОНГОЛ БАЗАЛЬТ ХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

**6 Борлуулалтын орлого**

(Мянган төгрөгөөр)	2023	2022
Чулуун хөвөн хавтангийн борлуулалт	10,007,912	13,973,383
Оёмол хөнжилийн борлуулалт	23,983	235,300
Шугам хоолойн борлуулалт	-	5,802
Базальт арматурын борлуулалт	9,737	-
Борлуулалтын хөнгөлөлт	(22,524)	-
Борлуулалтын буцаалт	-	(1,560)
<b>Нийт</b>	<b>10,019,108</b>	<b>14,212,925</b>

**7 Борлуулалтын өртөг**

(Мянган төгрөгөөр)	2023	2022
Борлуулалтын өртөг	6,736,199	10,268,992
<b>Нийт</b>	<b>6,736,199</b>	<b>10,268,992</b>

**8 Бусад орлого**

(Мянган төгрөгөөр)	2023	2022
Шатахууны картын урамшуулал	54,376	3,763
Даатгалын нөхөн олговор	3,601	-
<b>Нийт</b>	<b>57,977</b>	<b>3,763</b>

**9 Бусад олз / (гарз)**

(Мянган төгрөгөөр)	2023	2022
Гадаад валютын хэрэгжээгүй олз / (гарз)	(12,848)	90,636
Гадаад валютын хэрэгжсэн олз / (гарз)	(22,243)	27,454
<b>Нийт</b>	<b>(35,091)</b>	<b>118,090</b>

**10 Бусад зардал**

(Мянган төгрөгөөр)	2023	2022
Бараа материал данснаас хассан зардал	122,412	720
Хандив, тусламжийн зардал	5,670	15,376
Алданги, торгуулийн зардал	-	1,508
Бусад	2,000	-
<b>Нийт</b>	<b>130,082</b>	<b>17,604</b>

**МОНГОЛ БАЗАЛЬТ ХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

**11 Борлуулалт, маркетингийн зардал**

(Мянган төгрөгөөр)	2023	2022
Цалин ба холбогдох зардал	399,146	331,410
Маркетингийн зардал	217,083	174,370
Татвар, хураамжийн зардал	34,713	23,521
Шатахууны зардал	28,162	51,653
Түрээсийн зардал	20,889	46,687
Шуудан, холбооны зардал	19,799	39,291
Харул хамгаалалтын зардал	17,122	47,082
Сургалтын зардал	5,026	66,910
Даатгалын зардал	90	20,179
Бусад	163,572	72,947
<b>Нийт</b>	<b>905,602</b>	<b>874,050</b>

**12 Ерөнхий ба удирдлагын зардал**

(Мянган төгрөгөөр)	2023	2022
ТҮЗ-ЫН зардал	141,147	122,375
Цалин ба холбогдох зардал	169,530	37,732
Мэргэжлийн үйлчилгээний зардал	32,248	-
Даатгалын зардал	20,498	-
Шатахууны зардал	18,081	13,133
Албан томилолтын зардал	16,190	120,015
Сургалтын зардал	16,085	36,795
Шуудан, холбооны зардал	15,789	5,423
Хүлээн авалт, арга хэмжээний зардал	8,447	-
Түрээсийн зардал	1,500	-
Судалгааны зардал	-	437,021
Бусад	4,554	408
<b>Нийт</b>	<b>444,069</b>	<b>772,902</b>

**13 Хүүний орлого болон санхүүгийн зардал**

(Мянган төгрөгөөр)	2023	2022
Хүүний орлого – Хугацаатай хадгаламжууд (Тод 14)	78,985	9,465
Санхүүгийн зардал	(539,862)	(213,115)
<b>Нийт</b>	<b>(460,877)</b>	<b>(203,650)</b>

# МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

### 14 Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө данс нь дараах үлдэгдэлтэй байна.

(Мянган төгрөгөөр)	2023-12-31	2022-12-31
Касс дахь бэлэн мөнгө	1,340	25,253
Харилцах дахь мөнгө	107,880	463,910
Богино хугацаатай хадгаламж	5,620,625	939,164
<b>Нийт</b>	<b>5,729,845</b>	<b>1,428,327</b>

Харилцах дахь мөнгө нь Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж буй арилжааны банкуудад байршуулсан Ам.доллар, Монгол төгрөг, Оросын рубль болон Хятадын Юанийн данснуудын үлдэгдлийг илэрхийлнэ.

#### 14.1 Касс дахь бэлэн мөнгө

(Мянган төгрөгөөр)	2023-12-31	2022-12-31
Төгрөгийн үлдэгдэл	1,340	25,253
<b>Нийт</b>	<b>1,340</b>	<b>25,253</b>

#### 14.2 Харилцах дахь мөнгө

(Валютаар)	2023-12-31	2022-12-31
Төгрөг	102,301,340	98,282,532
Ам.доллар	535	104,689
Юань	3,821	672
Рубль	50,983	95,870

Харилцах дахь мөнгө

(Мянган төгрөгөөр)	2023-12-31	2022-12-31
Төгрөг	102,301	98,283
Ам.доллар	1,824	360,612
Юань	1,834	333
Рубль	1,921	4,682
<b>Нийт</b>	<b>107,880</b>	<b>463,910</b>

#### 14.3 Богино хугацаат хадгаламж

(Валютаар)	2023-12-31	2022-12-31
Төгрөг	4,916,321,917	5,157,404
Ам.доллар	206,499	100,533
Юань	-	1,186,331

# МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Богино хугацаат хадгаламж  
(Мянган төгрөгөөр)

	2023-12-31	2022-12-31
Төгрөг	4,916,322	5,157
Ам.доллар	704,303	346,298
Юань	-	587,709
<b>Нийт</b>	<b>5,620,625</b>	<b>939,164</b>

Гадаад валютын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь Монгол банкны албан ханшийн тэгшигтгэл хийгдэн үүссэн зөрүүг бодит бус олз, гарзаар хүлээн зөвшөөрөгдсөн. Хугацаатай хадгаламжийн данснаас Компани 2023 онд нийт 78,985 мянган төгрөг (2022: 9,465 мянган төгрөг)-ийн хүүний орлого олсон (Тодруулга 13).

### 15 Дансны авлага

(Мянган төгрөгөөр)	2023-12-31	2022-12-31
Дансны авлага	342,141	653,820
Найдваргүй авлагын хасагдуулга	(330,613)	(330,613)
<b>Нийт</b>	<b>11,528</b>	<b>323,207</b>

Дансны авлага нь хүүгүй бөгөөд харилцагч тус бүрийн нөхцлийг нь үндэслэн зээлийн борлуулалт хийдэг.

2023 болон 2022 онуудын найдваргүй авлагын хасагдуулгын хөдөлгөөн:

(Мянган төгрөгөөр)	2023-12-31	2022-12-31
1 сарын 1-ээрх үлдэгдэл	330,613	555,542
Тайлант хугацаанд нэмж байгуулсан	-	-
Тайланд хугацаанд хасагдсан	-	(220,442)
<b>12 сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>330,613</b>	<b>330,613</b>

2023 оны 12 дугаар сарын 31-ээрх дансны авлагын наажилт.

(Мянган төгрөгөөр)	0-90 өдөр	91-180 өдөр	181-270 өдөр	271-365 өдөр	365-аас дээш өдөр	Нийт
Дансны авлага	-	-	43	23,752	318,346	342,141
Хасагдуулга	-	-	-	(12,267)	(318,346)	(330,613)
<b>Нийт</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>43</b>	<b>11,485</b>	<b>-</b>	<b>11,528</b>

### 16 Бусад авлага

(Мянган төгрөгөөр)	2023-12-31	2022-12-31
Хувь хүнээс авах авлага	366,173	367,917
Ажиллагсдаас авах авлага	186,758	178,335
Онцгой албан татварын авлага	173	-
<b>Нийт</b>	<b>553,104</b>	<b>546,252</b>

Хувь хүн болон ажиллагсдаас авах авлагууд нь хүүгүй бөгөөд Компанийн удирдлага тухайн авлагууд нь ирэх 12 сарын хугацаанд эргэн төлөгднө гэж үзэж байна.

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 17 Бараа материал

(Мянган төгрөгөөр)	2023-12-31	2022-12-31
Бэлэн бүтээгдэхүүн	788,149	1,598,914
Хангамжийн материал	1,399,743	1,449,657
Түүхий эд материал	899,298	891,469
<b>Нийт</b>	<b>3,087,190</b>	<b>3,940,040</b>

Компани нь тайлант хугацааны эцэст бараа материалын тооллого хийдэг ба түүхэн өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийг хянаж үзэн аль бага дунгээр бүртгэдэг.

2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Компани өөрийн бараа материал, тоног төхөөрөмж мөн барилга, байгууламж зэргийг Хaan Банкнаас авсан ногоон зээлд барьцаалсан. Барьцаанд байгаа бараа материалын гэрээнд тусгагдсан үнэ нь 2,976,016 мянган төгрөг байна.

#### 18 Урьдчилж төлсөн зардал, тооцоо

(Мянган төгрөгөөр)	2023-12-31	2022-12-31
Худалдан авалтын урьдчилгаа – Үндсэн хөренгө	2,193,722	171,043
Худалдан авалтын урьдчилгаа – Бараа материал	767,176	1,133,580
Бусад татварын авлага	26,548	23,423
<b>Нийт</b>	<b>2,987,446</b>	<b>1,328,046</b>

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

19 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн өөрчлөлт, хөдөлгөөн дараах байдалтай байна. Компани нь үндсэн хөрөнгөө дахин үнэлгээний загвар ашиглан буртгэсэн, хөрөнгийн дун, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө хийдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн заслийн өгөөжийн хулээлдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах зорилгоор хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бурд хянаж уздэг.

(Мянган төгрөгөөр)	Барилга, байгууламж	Машин, тоног техвөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга, эд хогшил	Компьютер, дагалдах хэрэгсэл	Бусад хөрөнгө	Нийт
Өртөг							
2022 оны 1 сарын 1	1,623,608	14,034,423	1,294,835	145,594	123,513	1,347,246	18,569,219
Нэмэгдсан	1,010,366	312,316	516,330	37,865	42,839	1,059,463	2,979,180
Хасагдсан	-	-	-	-	-	-	-
2022 оны 12 сарын 31	2,633,974	14,346,739	1,811,165	183,459	166,352	2,406,709	21,548,399
Нэмэгдсан	280,948	2,207,018	228,549	82,906	20,172	2,660,331	5,479,924
Хасагдсан	(73,732)	-	(21,938)	(22,111)	(91,823)	(648,456)	(858,060)
2023 оны 12 сарын 31	2,841,190	16,553,757	2,017,776	244,254	94,701	4,418,584	26,170,263
Элэгдэл, үнэ цэнийн бууралт							
2022 оны 1 сарын 1	220,385	1,972,893	456,863	46,765	87,099	222,420	3,006,425
Нэмэгдсан	104,444	1,112,404	291,766	25,732	34,328	124,622	1,693,296
Хасагдсан	-	-	-	-	-	-	-
2022 оны 12 сарын 31	324,829	3,085,297	748,629	72,497	121,427	347,042	4,699,721
Нэмэгдсан	107,268	1,154,743	181,914	28,195	25,461	217,829	1,715,410
Хасагдсан	(21,213)	-	(19,379)	(21,872)	(91,808)	(135,653)	(289,925)
2023 оны 12 сарын 31	410,884	4,240,040	911,164	78,820	55,080	429,218	6,125,206
Дансны цэвэр дун							
2022 оны 12 сарын 31	2,309,145	11,261,442	1,062,536	110,962	44,925	2,059,667	16,848,677
2023 оны 12 сарын 31	2,430,306	12,313,717	1,106,612	165,434	39,621	3,989,366	20,045,056

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Компани өөрийн бараа материал, тоног төхөөрөмж мөн барилга, байгууламж зөргийг Хaan Банкнаас авсан зээлийн шугаманд барьцаалсан. Барьцаанд байгаа тоног төхөөрөмжийн гэрээнд тусгайдсан үнэлгээ нь 1,595,528,800 төгрөг, ул хөдлөх хөрөнгийн гарзэнд тусгайдсан үнэ нь 1,074,691,800 төгрөг тус тус байна.



# МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

### 20 Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийн өөрчлөлт, хөдөлгөөн дараах байдалтай байна. Компани биет бус хөрөнгийн хорогдлыг өмнөх жилийн үлдэх өргтөөс шууд хасч тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрдөг.

(Мянган төгрөгөөр)	Зохиогчийн эрх	Програм хангамж	Газар эзэмших эрх*	Бусад	Нийт
Өртөг / үнэлгээ					
2022 оны 1 сарын 1	2,020,000	42,532	12,311,709	15,000	14,389,241
Нэмэгдсэн	-	6,596	-	-	6,596
Дахин үнэлгээ	-	-	-	-	-
Данснаас хассан	(2,020,000)	-	-	-	(2,020,000)
2022 оны 12 сарын 31	-	49,128	12,311,709	15,000	12,375,837
Нэмэгдсэн	-	-	-	-	-
Дахин үнэлгээ	-	-	1,692,335	-	1,692,335
Данснаас хассан	-	(13,432)	-	-	(13,432)
2023 оны 12 сарын 31	-	35,696	14,004,044	15,000	14,054,740
Хорогдол					
2022 оны 1 сарын 1	134,593	18,410	726,852	5,466	885,321
Нэмэгдсэн	-	12,239	888,789	2,716	903,744
Хасагдсан	(134,593)	-	-	-	(134,593)
2022 оны 12 сарын 31	-	30,649	1,615,641	8,182	1,654,472
Нэмэгдсэн	-	13,148	486,797	2,715	502,660
Хасагдсан	-	(13,431)	-	-	(13,431)
2023 оны 12 сарын 31	-	30,366	2,102,438	10,897	2,143,701
Дансны цэвэр дүн					
2022 оны 12 сарын 31	-	18,479	10,696,068	6,818	10,721,365
2023 оны 12 сарын 31	-	5,330	11,901,606	4,103	11,911,039

Мөнх-Оргил Трэйд ХХК-ийн бэлтгэсэн Олон улсын үнэлгээний стандартад нийцүүлсэн хөрөнгийн (газар эзэмших эрх) үнэлгээний тайлангийн дагуу 2023 онд 1,692,335 мянган төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг газар эзэмших эрхийн бүртгэлд тусгасан болно.

### 21 Дансны өр төлбөр

(Мянган төгрөгөөр)	2023-12-31	2022-12-31
Дансны өр төлбөр	245,144	342,516
Нийт	245,144	342,516

Дансны өр төлбөр нь хүүгүй, ирэх 12 сарын хугацаанд төлж барагдуулна.

### 22 Бусад өр төлбөр

(Мянган төгрөгөөр)	2023-12-31	2022-12-31
Ногдол ашгийн өр төлбөр	729,846	-
Ажиллагсадад өгөх өр төлбөр	3,078	4,147
Нийт	732,924	4,147

Бусад өр төлбөр нь хүүгүй, 1-ээс 3 сарын хугацааны дотор төлөгднө.

# МОНГОЛ БАЗАЛЬТ ХХК

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

## 23 Орлогын албан татвар

Орлогын албан татварын зардал: (Мянган төгрөгөөр)	2023	2022
Татварын өмнөх ашиг	1,365,165	2,197,579
Татварын байнгын зөрүү:		
Тусгай хувь хэмжээтэй орлого	(82,586)	(9,465)
Хасагдахгүй зардал	197,702	23,706
Байнгын зөрүүгээр зохицуулагдсан татварын ногдуулах орлого:	<u>1,480,281</u>	<u>2,211,820</u>
Татварын түр зөрүү:		
Ханшийн зөруүний хэрэгжээгүй олз	12,848	(90,636)
Тайлант жилд хэрэгжсэн өмнөх үеийн хэрэгжээгүй олз	<u>-</u>	<u>-</u>
Түр зөрүүгээр зохицуулагдсан татвар ногдуулах орлого:	<u>1,493,129</u>	<u>2,121,184</u>
Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулсан татвар	149,313	212,119
Тусгай хувь хэмжээгээр бусдад суутгуулсан татвар	8,259	947
Тайлант жилийн нийт татварын зардал	<u>157,572</u>	<u>213,066</u>
Орлогын албан татварын өр төлбөр: (Мянган төгрөгөөр)	2023	2022
1 сарын 1-ээрх үлдэгдэл	113,842	244,634
Тайлан жилийн татварын зардал	157,572	213,066
Тайлант жилд төлсөн орлогын албан татвар	<u>(169,900)</u>	<u>(343,858)</u>
12 сарын 31-ээрх үлдэгдэл	<u>101,514</u>	<u>113,842</u>

## 24 Бусад татварын өр төлбөр

(Мянган төгрөгөөр)	2023-12-31	2022-12-31
НӨАТ-ын өр төлбөр	997,756	577,565
Хувь хүний орлогын албан татварын өр төлбөр	209,613	193,195
НДШ-ийн өр төлбөр	55	
Бусад татварын өр төлбөр	149	3,208
Нийт	<u>1,207,573</u>	<u>773,968</u>

## 25 Зээл

(Мянган төгрөгөөр)	Валют	Xүү	2023.12.31	2022.12.31
Хаан банкны шугамын зээл	Төгрөг	14.00%	-	1,957,000
Хаан банк – Монсейфф төслийн зээл	Төгрөг	14.40%	8,500,000	-
Хаан банк - Хадгаламж барьцаалсан зээл	Төгрөг	16.00%	504,000	-
Нийт			<u>9,004,000</u>	<u>1,957,000</u>

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Компанийн зээлийн үлдэгдэлд Хаан банк ногоон зээл 8,500,000 мянган төгрөгийн зээлтэй ба 36 сарын хугацаатай 2023 оны 5 дугаар сарын 29-нд авсан. Тухайн зээлийн үндсэн хүү нь жилийн 14.4% ба коммитмент хүү нь жилийн 1%. Компани шугаман зээлээ 2023 оны 12 дүгээр сарын 13-ний өдөр хаасан.

Богино хугацаат зээл:

(Мянган төгрөгөөр)	2023-12-31	2022-12-31
Хаан банкны зээлийн шугам	-	1,957,000
Хаан банкны төслийн зээл	2,231,501	-
Хаан банкны хадгаламж барьцаалсан зээл	504,000	-
<b>Нийт</b>	<b>2,735,501</b>	<b>1,957,000</b>

Компанийн дээрх зээлүүд нь богино хугацаатай бөгөөд хэвийн ангилалтай.

Үрт хугацаат зээл:

(Мянган төгрөгөөр)	2023-12-31	2022-12-31
Хаан банкны төслийн зээл	6,268,499	-
<b>Нийт</b>	<b>6,268,499</b>	<b>-</b>

#### 25.1 Барьцаанд байгаа хөрөнгө

Компанийн хөрөнгийн зарим хэсгийг Хаан банкны зээлийн шугамын батлан даалт болгож барьцаанд байршуулсан. Зээлийн гэрээгээрх барьцаалагдсан хөрөнгийн дэлгэрэнгүй дараах байдалтай байна.

Гэрээний хүрээн дэхь барьцаа хөрөнгийн үнэлгээ  
(Мянган төгрөгөөр)

	2023-12-31	2022-12-31
Бараа материал	2,976,016	699,363
Авлага	129,283	237,131
Машин, тоног төхөөрөмж	1,515,393	1,595,529
Үл хөдлөх хөрөнгө	1,074,692	1,741,159
Эзэмших эрхтэй газар	900,281	-
<b>Нийт</b>	<b>6,595,665</b>	<b>4,273,182</b>

26 Урьдчилж орсон орлого  
(Мянган төгрөгөөр)

	2023-12-31	2022-12-31
Урьдчилж орсон орлого	488,447	1,171,490
<b>Нийт</b>	<b>488,447</b>	<b>1,171,490</b>

27 Нөөц өр төлбөр  
(Мянган төгрөгөөр)

	2023-12-31	2022-12-31
Уурхайн нөхөн сэргээлтийн нөөц	543,777	543,777
Цалингийн эрсдлийн сан	198,501	198,011
<b>Нийт</b>	<b>742,278</b>	<b>741,788</b>

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 37 (Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө) -ийн дагуу Компани нь үндсэн түүхий эд болох Базалт чулууг олборлодог "Ногоон Уул" орд газартаа 543,777 мянган төгрөгийн нөхөн сэргээлтийн нөөцийг 2022 онд байгуулсан.

Тайлант хугацаанд нөөц сангудад өөрчлөлт ороогүй болно.

# МОНГОЛ БАЗАЛЬТ ХХК

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

**28 Цалингийн өр төлбөр**

(Мянган төгрөгөөр)	2023-12-31	2022-12-31
Цалингийн өр төлбөр	575	-
Нийт	575	-

**29 Эздийн өмч**

Хувьцаат капитал нь тайлант хугацааны эцэст дараах үлдэгдэлтэй байна:

Хувьцаа эзэмшигчид	Хувь эзэмшил	Эзэмшиж буй хувьцааны тоо	(Мянган төгрөгөөр)	
			2023-12-31	2022-12-31
Л.Ариунболд	35.7 %	20,140,869	2,014,087	2,014,087
П.Сайнбилэг	13.3 %	7,503,461	750,346	750,346
А.Энхгэрэл	7.0 %	3,949,190	394,919	394,919
А.Энхмаа	7.0 %	3,949,190	394,919	394,919
А.Энхжин	7.0 %	3,949,190	394,919	394,919
Бусад	30.0 %	16,925,100	1,692,510	1,692,510
Нийт	100.0 %	56,417,000	5,641,700	5,641,700

Компанийн дүрмийн сан нь тайлант хугацааны эцэст нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 56,417,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна.

**29.1 Нэмж төлөгдсөн капитал**

(Мянган төгрөгөөр)	2023-12-31	2022-12-31
Нэмж төлөгдсөн капитал	20,509,765	20,509,765
Нийт	20,509,765	20,509,765

**29.2 Хуриимтлагдсан ашгийн хөдөлгөөн**

(Мянган төгрөгөөр)	2023	2022
1 сарын 1-ээрх үлдэгдэл	2,450,426	2,095,502
Зарласан ногдол ашиг*	(1,128,340)	(964,167)
Өмнөх үеийн залруулга	-	(665,366)
Тайлант жилийн ашиг	1,207,594	1,984,514
12 сарын 31-ээрх үлдэгдэл	2,529,680	2,450,426

\* 2022 оны санхүүгийн гүйцэтгэлийг үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн шийдвэрээр 1,128,340 мянган төгрөгийн ногдол ашгийг зарлан, олгооор болсон.

**30 Эрсдлийн удирдлагын тогтолцоо**

Компанийн удирдлага нь Компанийн эрсдлийн удирдлагын тогтолцоог бий болгох, түүнийг хянах өрөнхий үүрэг хариуцлагыг хүлээж байдаг. Түүнчлэн Компанийн удирдлага нь эрсдлийн удирдлагын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих зэрэг үйл ажиллагаа өдөр тутам хийгдэж байгаа эсэхэд үүрэг хариуцлага хүлээдэг. Удирдлага нь хувьцаа эзэмшигчдэд үйл ажиллагааныхаа талаар тайлагнадаг.

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Компанийн эрсдлийн удирдлагын бодлого нь Компанид тулгарч буй эрсдлүүдийг тодорхойлох, шинжлэх, тохиromжтой эрсдлийн хязгаар, хяналтыг бий болгох, эрсдлийг хянах, хязгаарыг мөрдөх дэвшигчийн байдал. Эрсдлийн удирдлагын бодлого болон систем нь зах зээлийн нөхцөл байдал болон Компанийн үйл ажиллагаанд гарч байгаа аливаа өөрчлөлтүүдийг тусгахын тулд байнгын хяналт сайжруулалтын дор байдаг. Компани нь өөрийн сургалт, удирдлагын стандарт болон дүрэм журмаараа дамжуулан ажилтнууд үүрэг хариуцлагыг бүрэн ухамсарласан байх зохион байгуулалт бүхий, бүтээлч хяналт бүхий орчныг бий болгохоор зорин ажилладаг.

Компани нь зээлийн болон бусад эрсдлийн удирдлагаар хангах үүрэгтэй бөгөөд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зөвшөөрөл шаардлагатай буюу тодорхой түвшинээс дээших хэмжээний томоохон хэлцлүүдийг хянан үзэх байдлаар ажилладаг. Мөн түүнчлэн худалдан авалт болон борлуулалтын урт хугацаатай гэрээ, хэлцэл болон капитал хөрөнгө оруулалт, зээл зэрэг харьцангуй төвөгтэй урт хугацааны шинжтэй хэлцлүүдэд хэлэлцээр хийх болон зохион байгуулалтыг Хувьцаа эзэмшигчийн хурлаар хэлэлцэн шийдвэр гаргадаг.

#### 30.1 Төлбөрийн чадварын эрсдэл

Төлбөрийн чадварын эрсдэл нь санхүүгийн өр төлбөртэй хамаарал бүхий үүрэг хариуцлагаа биелүүлэхэд компанийд тулгарч болох аливаа хүндэрлүүд юм. Компанийн төлбөрийн чадвараа удирдах арга хандлага нь өр төлбөрийг хугацаанд нь барагдуулах хангалттай төлбөрийн чадвартай байх, үл хүлээн зөвшөөрөгдхөн аливаа алдагдлыг хүлээхгүй байх.

Дараах хүснэгтээрх мэдээлэл нь Компанийн санхүүгийн өр төлбөрийг төлөхөд бэлэн байдал, түүнийг төлөх нөөцийн боломжийг харуулна.

(Мянган төгрөгөөр)	2023-12-31	2022-12-31
<b>Санхүүгийн хөрөнгө</b>		
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	5,729,845	1,428,327
Дансны болон бусад авлага	564,632	869,459
<b>Нийт санхүүгийн хөрөнгө</b>	<b>6,294,477</b>	<b>2,297,786</b>
 <b>Санхүүгийн өр төлбөр</b>		
Дансны болон бусад өр төлбөр	(978,068)	(346,663)
Татварын өр төлбөр	(1,309,087)	(887,810)
<b>Нийт санхүүгийн өр төлбөр</b>	<b>(2,287,155)</b>	<b>(1,234,473)</b>
 <b>Цэвэр санхүүгийн хөрөнгө</b>	<b>4,007,322</b>	<b>1,063,313</b>

#### 30.2 Валютын ханшийн эрсдэл

Компани өөрийн үйл ажиллагааны валют болох төгрөгөөс бусад валютаар илэрхийлэгдсэн борлуулалт, худалдан авалт, зээлд гадаад валютын ханшийн эрсдлийг хүлээдэг. Эдгээр ажил гүйлгээний илэрхийлэгдсэн үндсэн валют нь Америкийн доллар, Хятадын юань болон ОХУ-ын рубль юм. Компани валютын ханшийн эрсдлээс зайлсхийхийн тулд гадаад валютын хэлбэлзлийг тогтмол хянаж, ирээдүйн гадаад валютын мөнгөн урсгалaa удирддаг.

Тайлант жилийн эцэс дэх Монгол Банкны хаалтын ханшийг дор үзүүлэв.

	2023.12.31 (төгрөг)	2022.12.31 (төгрөг)	Хэлбэлзэл /+/-
Мөнгөн тэмдэгт			
Ам.доллар	3,410.69	3,444.60	-33.91
ОХУ-ын рубль	37.67	48.85	-11.18
Хятадын юань	480.01	495.40	-15.39

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Компанийн эрсдлийн удирдлагын бодлого нь Компанид тулгарч буй эрсдлүүдийг тодорхойлох, шинжлэх, тохиromжтой эрсдлийн хязгаар, хяналтыг бий болгох, эрсдлийг хянах, хязгаарыг мөрдөх дэвшигчийн байдал. Эрсдлийн удирдлагын бодлого болон систем нь зах зээлийн нөхцөл байдал болон Компанийн үйл ажиллагаанд гарч байгаа аливаа өөрчлөлтүүдийг тусгахын тулд байнгын хяналт сайжруулалтын дор байдаг. Компани нь өөрийн сургалт, удирдлагын стандарт болон дүрэм журмаараа дамжуулан ажилтнууд үүрэг хариуцлагыг бүрэн ухамсарласан байх зохион байгуулалт бүхий, бүтээлч хяналт бүхий орчныг бий болгохоор зорин ажилладаг.

Компани нь зээлийн болон бусад эрсдлийн удирдлагаар хангах үүрэгтэй бөгөөд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зөвшөөрөл шаардлагатай буюу тодорхой түвшинээс дээших хэмжээний томоохон хэлцлүүдийг хянан үзэх байдлаар ажилладаг. Мөн түүнчлэн худалдан авалт болон борлуулалтын урт хугацаатай гэрээ, хэлцэл болон капитал хөрөнгө оруулалт, зээл зэрэг харьцангуй төвөгтэй урт хугацааны шинжтэй хэлцлүүдэд хэлэлцээр хийх болон зохион байгуулалтыг Хувьцаа эзэмшигчийн хурлаар хэлэлцэн шийдвэр гаргадаг.

#### 30.1 Төлбөрийн чадварын эрсдэл

Төлбөрийн чадварын эрсдэл нь санхүүгийн өр төлбөртэй хамаарал бүхий үүрэг хариуцлагаа биелүүлэхэд компанийд тулгарч болох аливаа хүндрэлүүд юм. Компанийн төлбөрийн чадвараа удирдах арга хандлага нь өр төлбөрийг хугацаанд нь барагдуулах хангалттай төлбөрийн чадвартай байх, үл хүлээн зөвшөөрөгдхөн аливаа алдагдлыг хүлээхгүй байх.

Дараах хүснэгтээрх мэдээлэл нь Компанийн санхүүгийн өр төлбөрийг төлөхөд бэлэн байдал, түүнийг төлөх нөөцийн боломжийг харуулна.

(Мянган төгрөгөөр)	2023-12-31	2022-12-31
<b>Санхүүгийн хөрөнгө</b>		
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	5,729,845	1,428,327
Дансны болон бусад авлага	564,632	869,459
<b>Нийт санхүүгийн хөрөнгө</b>	<b>6,294,477</b>	<b>2,297,786</b>
 <b>Санхүүгийн өр төлбөр</b>		
Дансны болон бусад өр төлбөр	(978,068)	(346,663)
Татварын өр төлбөр	(1,309,087)	(887,810)
<b>Нийт санхүүгийн өр төлбөр</b>	<b>(2,287,155)</b>	<b>(1,234,473)</b>
 <b>Цэвэр санхүүгийн хөрөнгө</b>	<b>4,007,322</b>	<b>1,063,313</b>

#### 30.2 Валютын ханшийн эрсдэл

Компани өөрийн үйл ажиллагааны валют болох төгрөгөөс бусад валютаар илэрхийлэгдсэн борлуулалт, худалдан авалт, зээлд гадаад валютын ханшийн эрсдлийг хүлээдэг. Эдгээр ажил гүйлгээний илэрхийлэгдсэн үндсэн валют нь Америкийн доллар, Хятадын юань болон ОХУ-ын рубль юм. Компани валютын ханшийн эрсдлээс зайлсхийхийн тулд гадаад валютын хэлбэлзлийг тогтмол хянаж, ирээдүйн гадаад валютын мөнгөн урсгалaa удирддаг.

Тайлант жилийн эцэс дэх Монгол Банкны хаалтын ханшийг дор үзүүлэв.

	2023.12.31 (төгрөг)	2022.12.31 (төгрөг)	Хэлбэлзэл /+/-
Мөнгөн тэмдэгт			
Ам.доллар	3,410.69	3,444.60	-33.91
ОХУ-ын рубль	37.67	48.85	-11.18
Хятадын юань	480.01	495.40	-15.39

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 30.3 Хүүний түвшний эрсдэл

Хүүгийн түвшний эрсдэл нь голдуу хөвөгч хүүтэй хадгаламж, зээлд тохиолдож болох хүүгийн түвшний ирээдүйд гарах өөрчлөлтийн хэлбэлзлийн эрсдэл юм. Хүүгийн түвшний эрсдлийн удирдлагын зорилго нь санхүүгийн зардлыг хамгийн бага байлгах болон хүүгийн түвшний өөрчлөлттэй холбоотой тодорхой бус байдлыг бууруулахад чиглэдэг.

Хүүгийн түвшний өөрчлөлттэй холбоотойгоор хүлээх зах зээлийн эрсдэл нь голдуу Компанийн зээлтэй хамааралтай байдаг.

#### 30.4 Үйл ажиллагааны эрсдэл

Компанийн санхүүгийн удирдлагын бодлого болон зарчим нь компанийн зээлжих дээд хязгаар, капиталын бүтэц, эргэлтийн хөрөнгийн удирдлага, хөrvөх чадварууд дээр санхүүгийн харьцаануудын зохистой түвшинг тогтоо замаар санхүүгийн болон үйл ажиллагааны шилдэг арга туршлагыг нэвтрүүлэхийг зорилго болгодог байна. Мөн түүнчлэн зорилтот ашигт ажиллагаа, өөрийн хөрөнгийн өгөөжийн түвшинг тогтоохдоо зах зээлийн нөхцөл байдал болон зорилтот салбарын онцлогийг харгалзан үздэг.

Санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд Компанийн хөрөнгө оруулалт болон тогтоосон санхүүгийн харьцаануудыг тодорхой түвшинд хангаж байх хэмжээнд өөрсдийн бизнесийн төлөвлөгөө болон үйл ажиллагааны төсвийг боловсруулж, хэлэлцэн хэрэгжүүлдэг. Түүнчлэн, санхүүгийн харьцаануудын гүйцэтгэлийн биелэлт нь жилийн гүйцэтгэлийн үнэлгээний системд багтсан ба гүйцэтгэх удирдлагын багийн гүйцэтгэлийн үнэлгээ болон тэдний цалингийн хувьсах бүрэлдэхүүн хэсэгт (урамшуулал цалин) чухал ач холбогдолтой. Компанийн санхүүгийн удирдлагад ашиглагддаг хамгийн түгээмэл санхүүгийн харьцаанууд нь:

- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа = Эргэлтийн хөрөнгө/Богино хугацаат өр төлбөр;
- Зээл/Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг (ХТЭХӨА);
- Эргээцийн харьцаа, хоног (авлага, бараа материал болон өр төлбөр);
- Зээлийн үйлчилгээ хийх чадварын харьцаа = Чөлөөт мөнгөн урсгал/Зээлийн үйлчилгээний дүн;
- Өгөөжийн дотоод норм;
- Ашигт ажиллагааны зорилтот түвшин: ХТЭХӨА маржин, татварын дараах ашгийн маржин.

Компани нь зорилтот хөрөнгө оруулалтын өгөөжийг бий болгохын зэрэгцээ, компанийн хэмжээнд эрсдлийг хамгийн бага хэмжээнд байлгахын тулд эрсдлийн иж бүрэн цогц удирдлагын системийг бий болгооор зорин ажиллаж байна.

#### 31 Капиталын удирдлага

Компанийн капиталд хөрөнгө удирдлагын зорилгоор, хөrvөх нөхцөлтэй хувьцаа, хувьцааны урамшуулал болон эздийн өмчид хуваарилагдах бусад бүх капиталын нөөцийг оруулна. Компанийн хөрөнгийн удирдлагын үндсэн зорилго нь өөрийн бизнесийг дэмжих ба хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

Компанийн өрийг өмчид харьцуулсан харьцааг тайлант хугацааны эцэст илэрхийлбэл:

(Мянган төгрөгөөр)	2023-12-31	2022-12-31
Нийт өр төлбөр*	12,522,455	5,104,751
Нийт эздийн өмч	31,802,753	30,031,165
Өрийн харьцаа	39.38%	17%

\* Өр нь нийт татварын өр, нийт бусад өр төлбөрийг хамруулсан.

# МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

### 32 Холбоотой талууд

#### 32.1 Хувьцаа эзэмшигчид болон Компанийн удирдлага

Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд холбоотой талуудын хамаарал болон хийгдсэн ажил гүйлгээ байдалтай байна.

№	Холбоотой талууд	Харьяалал	Харилцаа хамаарал	Гүйлгээ
1	Л.Ариунболд	Монгол улс, иргэн	Хувьцаа эзэмшигч, ТУЗ-ын дарга	Ногдол ашиг, цалин хөлс
2	П.Сайнбилиг	Монгол улс, иргэн	Хувьцаа эзэмшигч	Ногдол ашиг
3	А.Энхгэрэл	Монгол улс, иргэн	Хувьцаа эзэмшигч, Гүйцэтгэх захирал	Ногдол ашиг, цалин хөлс
4	А.Энхмаа	Монгол улс, иргэн	Хувьцаа эзэмшигч	Ногдол ашиг
5	А.Энхжин	Монгол улс, иргэн	Хувьцаа эзэмшигч, ажилтан	Ногдол ашиг, цалин хөлс

#### 32.2 Холбоотой талуудтай хийгдсэн ажил гүйлгээ:

##### Холбоотой талуудын 2023 оны ногдол ашгийн гүйлгээ

Холбоотой тал	Хувьцааны тоо	Нэгж хувьцаанд ногдох ашиг /төгрөг/	Зарласан ногдол ашиг /мянган төгрөг/	Суутгуулсан ХХОАТ 5% /мянган төгрөг/	Хүлээн авсан ногдол ашиг /мянган төгрөг/
Л.Ариунболд	20,140,869	20.00	402,817	20,141	382,677
П.Сайнбилиг	7,503,461	20.00	150,069	7,503	142,566
А.Энхгэрэл	3,949,190	20.00	78,984	3,949	75,035
А.Энхмаа	3,949,190	20.00	78,984	3,949	75,035
А.Энхжин	3,949,190	20.00	78,984	3,949	75,035
Нийт	39,491,900	20.00	789,838	39,491	750,348

##### Холбоотой талуудын 2023 оны цалин хөлсний гүйлгээ

Холбоотой тал	Цалин урамшуулал /мянган төгрөг/	Суутгасан НДШ /мянган төгрөг/	Суутгуулсан ХХОАТ /мянган төгрөг/	Хүлээн авсан цалин урамшуулал /мянган төгрөг/
Л.Ариунболд	79,440	7,590	7,185	64,665
П.Сайнбилиг	15,388	1,431	1,192	12,765
А.Энхгэрэл	72,950	7,590	6,536	58,824
А.Энхжин	12,000	1,380	846	9,774
Нийт	179,778	17,991	15,759	146,028

#### 32.3 Бусад холбоотой талууд

Бусад холбоотой талуудад хувьцаа эзэмшигчид болон тэдний гэр бүлийн гишүүд болон гишүүдтэй холбоотой байгууллагууд, компанийтай адил нэг захирал эсвэл гол удирдлагатай байгууллагууд, захирал болон гол удирдлага мөн тэдгээрийн гэр бүлийнхэнтэй холбоотой байгууллагууд хамаарна.

## МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 33 Үүрэг хариуцлага ба болзошгүй зүйлс

Хууль, эрх зүй

Компани нь бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад ч хуулийн аливаа зарга маргаан болон гомдолтой холбогдож болно. Хэрэв аливаа зарга маргаан, гомдол гарсанаас ямар нэгэн үүрэг хариуцлага үүсвэл энэ нь Компанийн ирээдүйн үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн байдалд материаллаг сөрөг нөлөө үзүүлэхгүй гэдэгт удирдлага итгэлтэй байна.

#### 34 Тайлангийн дараах үйл явдал

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн шийдвэрээр 2023 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 21 төгрөг буюу нийт 56,417,000 хувьцаанд 1,184,757 мянган төгрөгийн ногдол ашиг зарлан, 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор олгохоор болсон.

Удирдлага нь санхүүгийн тайланд нөлөөлөхүйц тайлант хугацааны дараа гарсан бусад үйл явдал байхгүй гэж үзэж байна.

#### 35 Монгол хэл дээрх орчуулга

Энэхүү санхүүгийн тайлан нь Англи, Монгол хэл дээр бэлтгэгдсэн бөгөөд Англи, Монгол хэл дээрх хувилбаруудын хооронд утга, агуулгын зөрүү үүссэн тохиолдолд Англи хувилбарыг баримтална.